

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын  
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2025/056/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Говьсүмбэр аймаг  
2025 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа  
Утас: 70543179  
Цахим хаяг: [sarantuyab@audit.gov.mn](mailto:sarantuyab@audit.gov.mn)  
Аудитын менежер: Г.Наранбаяр  
Цахим хаяг: [baranbayarg@audit.gov.mn](mailto:baranbayarg@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Анхтуяа  
Цахим хаяг: [ankhtuyab@audit.gov.mn](mailto:ankhtuyab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	20
4.1 Ерөнхий зүйл .....	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	21
4.5.1 Завсрын аудитын талаар.....	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	24
5.1 Төлбөрийн акт.....	25
5.2 Албан шаардлага .....	25
5.3 Зөвлөмж.....	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	27

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандарт
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: govisumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
Д.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

2025.02.19 № 21

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

422502072

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>107,890,353.24</u></b>	<b><u>196,012,009.24</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	4,242,713.81	15,977,369.81
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	4,242,713.81	15,977,369.81
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	4,242,713.81	15,977,369.81
31218	Ахмадын сангийн харилцах	4,242,713.81	15,977,369.81
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	31,914,189.43	31,914,189.43
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	54,542.43	54,542.43
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	31,859,647.00	31,859,647.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	31,859,647.00	31,859,647.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	44,633,950.00	84,870,450.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	26,633,950.00	66,870,450.00
35410	Бичиг хэргийн материал	103,000.00	825,900.00
35420	Аж ахуйн материал	-	108,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	16,220,000.00
35470	Бусад хангамжийн материал	26,530,950.00	49,716,550.00
35600	Мал амьтад	18,000,000.00	18,000,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	27,099,500.00	63,250,000.00
36600	Бусад нөөц	27,099,500.00	63,250,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,222,871,433.84</u></b>	<b><u>1,139,625,878.81</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,222,871,433.84	1,139,625,878.81
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,207,962,600.40	1,002,067,045.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,049,883,096.13	1,049,565,096.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(608,343,637.90)	(677,325,154.23)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	302,178,550.00	286,618,550.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(117,332,300.21)	(133,403,025.42)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	116,462,683.00	120,252,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(72,144,377.91)	(61,310,663.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,011,598.50	64,884,618.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,907,976.57)	(21,846,204.98)
39209	Зам, гүүрийн байгууламж	499,815,745.00	499,815,745.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(333,072,768.36)	(334,316,111.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	818,285,901.03	782,823,317.74
39215	Хуримтлагдсан элэгдэл	(486,873,912.31)	(573,691,322.63)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	14,908,833.44	137,558,833.48
39301	Програм хангамж	4,870,050.00	1,710,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,399,216.56)	(1,029,166.52)
39303	Бусад биет бус хөрөнгө	14,438,000.00	136,878,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,330,761,787.08</u></b>	<b><u>1,335,637,888.05</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,680,000.00</u></b>	<b><u>0.00</u></b>

41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,680,000.00	0.00
413	<b>Өглөг</b>	1,680,000.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,680,000.00	0.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,329,081,787.08</b>	<b>1,335,637,888.05</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,329,081,787.08	1,335,637,888.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	639,608,941.55	639,608,941.55
51101	Өмч: - төрийн	639,608,941.55	639,608,941.55
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(77,985,956.75)	(71,429,855.78)
51210	Өмнөх үеийн үр дүн	(77,985,956.75)	(80,474,206.81)
51220	Тайлант үеийн үр дүн	-	9,044,351.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	767,458,802.28	767,458,802.28
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,330,761,787.08</b>	<b>1,335,637,888.05</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,478,544,016.49</b>	<b>1,622,875,444.24</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>576,755,548.04</b>	<b>438,351,691.24</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	576,755,548.04	438,351,691.24
120009	Бусад орлого	-	1,843,100.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	514,595,548.04	292,468,581.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	62,160,000.00	144,040,010.24
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>901,788,468.45</b>	<b>1,184,523,753.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	14,958,000.00	15,865,653.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,110,653.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,958,000.00	880,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	875,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	886,830,468.45	1,168,658,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	886,830,468.45	1,168,658,100.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,238,386,538.31</b>	<b>1,612,874,426.49</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,238,386,538.31</b>	<b>1,612,874,426.49</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,172,544,612.16	1,533,697,766.69
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	434,533,627.81	589,286,729.34
210101	Үндсэн цалин	319,403,832.12	311,957,781.93
210102	Нэмэгдэл	43,748,678.69	160,316,745.35

210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,600,000.00	33,990,000.00
210104	Урамшуулал	30,296,955.00	35,330,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,484,162.00	47,691,502.06
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53,527,565.96	69,777,296.39
210201	Тэтгэврийн даатгал	38,041,746.94	48,769,329.40
210202	Тэтгэмжийн даатгал	4,460,551.33	5,613,512.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,526,092.80	2,842,547.36
210204	Ажилгүйдлийн даатгал	679,517.07	2,379,503.79
210205	Эрүүл мэндийн даатгал	6,819,657.82	10,172,403.13
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	103,117,231.74	118,070,918.11
210301	Гэрэл, цахилгаан	19,558,817.74	20,540,104.11
210302	Түлш, халаалт	80,082,750.00	81,760,684.00
210303	Цэвэр, бохир ус	3,475,664.00	15,770,130.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	56,692,937.64	106,457,713.48
210401	Бичиг хэрэг	6,928,400.00	8,325,270.00
210402	Тээвэр, шатахуун	43,377,679.00	51,944,440.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,809,908.64	3,988,173.48
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	640,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,396,950.00	35,345,330.00
210408	Бараа материал актальсны зардал	-	2,899,500.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	-	3,315,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,384,600.00	-
210502	Хоол, хүнс	2,384,600.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	20,697,630.00	222,000.00
210604	Урсгал засвар	20,697,630.00	222,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	10,296,000.00	11,554,700.00
210702	Дотоод албан томилолт	10,296,000.00	11,554,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	61,807,477.92	62,694,892.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,810,477.92	61,495,467.78
210803	Даатгалын үйлчилгээ	1,560,000.00	433,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	250,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	166,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	250,000.00
210807	Газрын төлбөр	-	100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	429,487,541.09	575,633,516.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,213,475.00	162,034,897.34
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,240,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	355,274,066.09	412,358,619.25
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	65,841,926.15	79,176,659.80
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	8,743,330.00	13,310,653.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	9,110,653.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,743,330.00	4,200,000.00



2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	57,098,596.15	65,866,006.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,754,596.15	65,866,006.80
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,344,000.00	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>240,157,478.18</u></b>	<b><u>10,001,017.75</u></b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	956,666.72
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	956,666.72
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(956,666.72)
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>240,157,478.18</u></b>	<b><u>9,044,351.03</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>901,788,468.45</u></b>	<b><u>1,199,958,409.00</u></b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>15,434,656.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	15,434,656.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	15,434,656.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	15,434,656.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>901,788,468.45</u></b>	<b><u>1,184,523,753.00</u></b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	14,958,000.00	15,865,653.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,110,653.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,958,000.00	880,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	875,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	886,830,468.45	1,168,658,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	886,830,468.45	1,168,658,100.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>889,883,668.45</u></b>	<b><u>1,150,824,353.00</u></b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>889,883,668.45</u></b>	<b><u>1,150,824,353.00</u></b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>824,041,742.30</u></b>	<b><u>1,070,447,693.20</u></b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	426,934,713.86	602,878,285.34
210101	Үндсэн цалин	235,740,966.57	327,959,442.65
210102	Нэмэгдэл	100,478,887.16	159,698,450.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,434,055.73	33,607,911.00
210104	Урамшуулал	38,150,146.00	34,739,537.50

210105	Гэрээт ажлын хөлс	24,130,658.40	46,872,943.34
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>53,454,648.81</b>	<b>69,777,296.39</b>
210201	Тэтгэврийн даатгал	38,455,358.78	48,743,079.40
210202	Тэтгэмжийн даатгал	6,664,176.61	5,613,512.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,296,879.71	2,806,756.36
210204	Ажилгүйдлийн даатгал	543,611.93	2,415,294.79
210205	Эрүүл мэндийн даатгал	5,494,621.78	10,198,653.13
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>103,117,231.74</b>	<b>118,070,918.11</b>
210301	Гэрэл, цахилгаан	19,558,817.74	20,540,104.11
210302	Түлш, халаалт	80,082,750.00	81,760,684.00
210303	Цэвэр, бохир ус	3,475,664.00	15,770,130.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,854,078.64</b>	<b>35,241,873.48</b>
210401	Бичиг хэрэг	3,849,500.00	7,405,670.00
210402	Тээвэр, шатахуун	12,898,200.00	19,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,809,908.64	4,157,173.48
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	640,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,116,470.00	3,539,030.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>299,500.00</b>	<b>-</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	299,500.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>32,790,610.00</b>	<b>38,698,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,092,000.00	1,548,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	124,000.00	-
210604	Урсгал засвар	30,574,610.00	37,150,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>10,438,000.00</b>	<b>11,554,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	10,438,000.00	11,554,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>118,017,134.25</b>	<b>93,015,592.78</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	115,860,634.25	91,716,167.78
210803	Даатгалын үйлчилгээ	1,560,000.00	433,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	250,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	166,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	519,500.00	350,000.00
210807	Газрын төлбөр	-	100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>58,135,825.00</b>	<b>101,210,127.10</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,007,825.00	99,970,127.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	128,000.00	1,240,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>65,841,926.15</b>	<b>80,376,659.80</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,743,330.00</b>	<b>14,510,653.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	9,110,653.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,743,330.00	5,400,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>57,098,596.15</b>	<b>65,866,006.80</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,754,596.15	65,866,006.80

213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,344,000.00	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>11,904,800.00</u></b>	<b><u>49,134,056.00</u></b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>14,204,800.00</b>	<b>37,399,400.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>14,204,800.00</b>	<b>37,399,400.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	14,204,800.00	37,399,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,204,800.00	37,399,400.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(14,204,800.00)</u></b>	<b><u>(37,399,400.00)</u></b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(2,300,000.00)	11,734,656.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	6,542,713.81	4,242,713.81
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	4,242,713.81	15,977,369.81

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	639,608,941.55	767,458,802.28	(246,356,398.69)	-	1,160,711,345.14
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>639,608,941.55</b>	<b>767,458,802.28</b>	<b>(246,356,398.69)</b>	-	<b>1,160,711,345.14</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	240,157,478.18	-	240,157,478.18
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>639,608,941.55</b>	<b>767,458,802.28</b>	<b>(6,198,920.51)</b>	-	<b>1,400,868,823.32</b>
D01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>639,608,941.55</b>	<b>767,458,802.28</b>	<b>(6,198,920.51)</b>	-	<b>1,400,868,823.32</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>639,608,941.55</b>	<b>767,458,802.28</b>	<b>(6,198,920.51)</b>	-	<b>1,400,868,823.32</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	9,044,351.03	-	9,044,351.03
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>639,608,941.55</b>	<b>767,458,802.28</b>	<b>2,845,430.52</b>	-	<b>1,409,913,174.35</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,343,363,100.00</b>	<b>1,102,792,093.20</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,343,363,100.00</b>	<b>1,102,792,093.20</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,336,238,100.00</b>	<b>1,097,392,093.20</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	740,925,000.00	602,878,285.34
210101	Үндсэн цалин	369,535,400.00	327,959,442.65
210102	Нэмэгдэл	288,899,600.00	159,698,450.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,740,000.00	33,607,911.00
210104	Урамшуулал	47,750,000.00	34,739,537.50
210105	Гэрээт ажлын хөлс	-	46,872,943.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,612,100.00	69,777,296.39
210201	Тэтгэврийн даатгал	66,592,100.00	48,743,079.40
210202	Тэтгэмжийн даатгал	6,520,000.00	5,613,512.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,220,000.00	2,806,756.36
210204	Ажилгүйдлийн даатгал	1,260,000.00	2,415,294.79
210205	Эрүүл мэндийн даатгал	13,020,000.00	10,198,653.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120,000,000.00	118,070,918.11
210301	Гэрэл, цахилгаан	30,000,000.00	20,540,104.11
210302	Түлш, халаалт	80,000,000.00	81,760,684.00
210303	Цэвэр, бохир ус	10,000,000.00	15,770,130.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,900,000.00	34,531,873.48
210401	Бичиг хэрэг	6,700,000.00	6,695,670.00
210402	Тээвэр, шатахуун	19,000,000.00	19,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000,000.00	4,157,173.48
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	640,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,000.00	3,539,030.00
2105	Нормативт зардал	500,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,653,000.00	68,968,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,000,000.00	31,817,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	-
210604	Урсгал засвар	37,153,000.00	37,150,900.00
2107	Томилолт, зочны зардал	11,500,000.00	10,674,700.00
210702	Дотоод албан томилолт	11,500,000.00	10,674,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	112,903,000.00	92,850,592.78

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	109,853,000.00	91,551,167.78
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	433,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	250,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200,000.00	166,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	350,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>161,245,000.00</b>	<b>99,640,127.10</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	148,745,000.00	98,400,127.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,500,000.00	1,240,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,125,000.00</b>	<b>5,400,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,125,000.00</b>	<b>5,400,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,125,000.00	5,400,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,326,743,100.00</b>	<b>1,102,792,093.20</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,326,743,100.00</b>	<b>1,102,792,093.20</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,326,743,100.00	1,102,792,093.20
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>27.00</b>	<b>22.00</b>
620001	Удирдах ажилтан	5.00	5.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	4.00
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>15,865,653.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>15,865,653.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,755,000.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>710,000.00</b>
210401	Бичиг хэрэг	710,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>880,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	880,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>165,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	165,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,000,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,110,653.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,110,653.00</b>

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,110,653.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>15,865,653.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>15,865,653.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,110,653.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	880,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	875,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын чиг үүргийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа

##### 2024 онд дэвшүүлсэн зорилт:

1. Аймаг, сумын засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд мэргэшсэн боловсон хүчний зөвлөгөө дэмжлэгээр хангана
2. Иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хуулийн хүрээнд хүргэнэ
3. Ажилтан, албан хаагчдын ур чадвар, мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх нөхцөлөөр нөхцөл боломжоор хангах замаар байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, нөлөөг сайжруулна
4. Сумын нийгэм, эдийн засгийн үйл ажиллагааг байнга дээшлүүлж, харилцагч байгууллагуудыг бодлогоор дэмжиж ажиллана
5. Олон улсын стандартад суурилсан төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай хүргэсэн сум байна

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт
- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай"
- Сангийн сайдын 2024 оны 52 дугаар тушаалаар батлагдсан "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай"
- Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"
- Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ



илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тайлан хугацаанд өөрчлөлт орсон байна. 2024 оны А/35 дугаар даргын тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,876.2 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,242.7	15,977.4	11,734.7
Авлага	31,914.2	31,914.2	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	71,733.5	148,120.5	76,387.0
Үндсэн хөрөнгө	1,222,871.4	1,139,625.9	83,245.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,330,761.8</b>	<b>1,335,638.0</b>	<b>4,876.2</b>
Өр төлбөр	1,680.0	0.0	(1,680.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,329,081.8	1,335,638.0	6,556.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,330,761.8</b>	<b>1,335,638.0</b>	<b>4,876.2</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах нөлөө бүхий дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 11,734.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ахмадын сангийн харилцах дансны үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 148,120.5 мянган төгрөг болж, 76,387.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 130,100.0 мянган төгрөгийн өвс, тэжээл, хайлаас, шар мод, гамшгаас сэргийлэх арга хэмжээний зардлаас 11,250.0 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,139,625.9 мянган төгрөг болж 83,245.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоос шалтгаалжээ. Тухайлбал, үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалт 40,089.4 мянга, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 10,100.0 мянга, дахин үнэлгээгээр 69 ширхэг 282,368.6 мянга, нийт 332,558.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Аймгийн ИТХ-ын 2024 оны 120 дугаар захирамжаар 2,870.0 мянган төгрөгийн 9 ширхэг

хөрөнгийг шилжүүлсэн, 2024 оны 124 дүгээр захирамжаар 249,396.1 мянган төгрөгийн 135 ширхэг хөрөнгийг данснаас хассан байна.

- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,335,638.0 мянган төгрөг болж 4,876.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,536,283.0 мянга, нийт зарлагыг 1,536,283.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 289,592.9 мянган төгрөгөөр бууруулж, 1,246,690.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин хөлс, тэтгэмж урамшуулал, тогтмол зардлыг нэмэгдүүлж төлөвлөснөөс шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 80,053.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,326,743.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр батлагдсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,168,658.1 мянга буюу 12 хувиар дутуу санхүүжилт олгосон байна. Энэ нь орон нутгийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-80101	1,032,458.0	877,596.3	154,861.7	85.0
2	70106-80106	97,342.1	81,710.2	15,631.9	83.9
3	70106-80205	940.0	440.0	500.0	46.8
4	70106-80802	4,900.0	4,900.0	0.0	100.0
5	70106-81102	56,100.0	45,085.6	11,014.4	80.4
6	70106-81701	25,800.0	7,550.8	18,249.2	29.3
7	70106-82212	79,203.0	70,309.2	8,893.8	88.8
8	70106-83110	30,000.0	15,200.0	14,800.0	50.7
	<b>Нийт</b>	<b>1,326,743.1</b>	<b>1,102,792.1</b>	<b>223,951.0</b>	<b>83.1</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,102,792.1 мянган төгрөг буюу 83.1 хувьтай байгаа нь орон төсвийн бүрдүүлэлтээс шалтгаалан 158,085.0 мянган төгрөгийн дутуу санхүүжилт олгосонтой холбоотой байна.

Судалгааны дүнгээр тус байгууллага нь жилийн эцэст ахмадын сангийн дансанд төсвийн зарцуулаагүй үлдэгдлээс 15,434.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, 210801, 210901 зардлын зардлын зориулалт арга хэмжээний дагуу зарцуулсан, 5 орон тоо дутуу ажилласан байна.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд хандивын орлого 5,000.0 мянга, төрийн захиргааны албан хаагчийн мөнгөн урамшуулал 9,110.7 мянга, цахим тендерийн хураамжийн орлого 875.0 мянга, Статистикийн хэлтсийн тооллогын зардалд 880.0 мянга нийт 15,865.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Өвсний зардалд 5,000.0 мянга, төрийн захиргааны албан хаагчийн мөнгөн урамшууллын зардалд 9,110.7 мянга, бичиг хэргийн материалын зардалд 875.0 мянга, томилолтын зардалд 880.0 мянга, нийт 15,865.7 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

#### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн авлага, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Анхтуяа, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/53 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дүн 1,238,386.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,383.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус байгууллага нь орон тоо төсөв нь батлагдаагүй 2 орон тоонд /гамшиг, ХАБЭА / ажил хавсарсны нэмэгдэл 8,726.5 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.2.6 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5-н сая төгрөгөөс дээш худалдан авалт цэст 277,729.2 мянган төгрөгийн 14 худалдан авалтыг мэдээлсэн боловч бараа ажил үйлчилгээний нэр, ажил үйлчилгээний утга тодорхойгүй мэдээлсэн, нийт 53,547.1 мянган төгрөгийн 14 шийдвэр хугацаа хоцорч мэдээлсэн

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 7 дугаар зүйлийн 7.1.1-д "Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан", 7.1.3-т "тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.2.5-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 2.2.3.2-т "зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 3 дугаар зүйлийн 3.2.9-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээг гэрээ, хэлцэл, санхүүжилт өгснөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар", 3.2.11-д "зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар" дэх заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, хугацаа хоцроож мэдээлэхгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчил илрээгүй байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус байгууллагад 2024 оны 2 дугаар улирлын байдлаар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд завсрын аудит гүйцэтгэж, нийт 6 горим сорилыг хэрэгжүүлж, асуудлын бүртгэлээр 4,670.7 мянган төгрөгийн 4 алдааг залруулах зөвлөмж өгсөн байна. Нийт 4,670.7 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

**Залруулсан алдаа:**

1. Үндсэн хөрөнгийн шинж чанаргүй 3 хөрөнгийг машин тоног төхөөрөмж дансанд 2,690.0 мянган төгрөгөөр бүртгэж, 10 жилийн ашиглалтын хугацаатай орлогод авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэл журам"-ыг зөрчсөн, УСНББОУС 17.14-д Үндсэн хөрөнгө-Хүлээн зөвшөөрүүлэлт "Үндсэн хөрөнгийн өртгийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө: а) Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавх нь тухайн байгууллагад орох нэлээд их магадлалтай байх б) Тухайн хөрөнгийн өртөг буюу үйлчилгээний чадавхыг найдвартай хэмжих чадах", Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй
2. 2 дугаар сард ажлын цагийн тооцоо гаргаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын НХМаягт ЦХ-2 зөрчсөн, НББОУС 18 Орлого, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй
3. Тайлант хугацаанд өмнөх онд үүссэн 1,680.0 албан томилолтын өглөгийг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.5 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС-19 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө, НББОУС-37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө, Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.
4. Тээвэр шатахууны 300.7 мянган төгрөгийн зардлыг арвилан хэмнэлтгүй зарцуулсан /Жолоочийн тооцооны хуудсанд сумаас аймаг руу ирж, очих км-ийг ялгаатай, харилцан адилгүй тооцоолсон/ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын НХМаягт ТМ-4 дахь заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,830.0	2	1,830.0	100
Албан шаардлага	1	4,890.5	1	4,890.5	100
Зөвлөмж	3	2,479.8	3	2,479.8	100
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>6,200.3</b>	<b>6</b>	<b>6,200.3</b>	<b>100</b>

Өмнөх аудитаар нийт 6,200.3 мянган төгрөгийн 6 зөрчил илрүүлж, 1,830.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 4,890.5 мянган төгрөгийн албан шаардлага, 2,479.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг хянаж үзэхэд 100%-тай байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн **/барилга, их засвар, урсгал засвар г.м/** ажлыг бөөн дүнгээр бүртгэхгүй байх /хөрөнгийн сайжруулалт/, ажил, тоо, хэмжээ нэг бүрээр салгаж бүртгэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 293,279.6 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 293,279.6 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

### **Залруулсан алдаа:**

1. *Жилийн эцсээр ахмадын сангийн дансанд төвлөрүүлсэн 15,434.6 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч алдаатай бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого (татвар ба шилжүүлэг), НББОУС 18 Орлого , MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", ангилал батламж мэдэгдлийг хангаагүй*
2. *Сумын Орон нутгийн хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцөлийг дэмжих, байр засварлах" засварын ажлыг үндсэн хөрөнгийн барилга байгууламж дансанд хөрөнгийн өртгийг нэмэгдүүлж хөрөнгийн сайжруулалт хийж бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэл журам" 10.13.Үндсэн хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд бодит үнэ цэнээр хэмжинэ. 10.14.Байгууллага нь материаллаг дүн бүхий томоохон үндсэн хөрөнгө, барилга, дэд бүтцийн хөрөнгийн бүрэлдэхүүнд багтдаг зүйлийг орлуулж, сольж байгаа тохиолдолд хасаж байгаа зүйлийн өртгийг зардлаар хүлээн зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь орлуулагдан хасагдаж буй зүйлийн дансны үнийг тодорхойлох практик боломжгүй байвал уг орлуулан нэмэгдэж буй өртгийг ашиглаж болно" заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 17.14-д Үндсэн хөрөнгө-Хүлээн зөвшөөрүүлэлт "Үндсэн хөрөнгийн өртгийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө: а) Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавх нь тухайн байгууллагад орох нэлээд их магадлалтай байх б) Тухайн хөрөнгийн өртөг буюу үйлчилгээний чадавхыг найдвартай хэмжих чадах", үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй*
3. *Үр дүнгийн тайланд сахилгын шийтгэл ногдуулах шийдвэрийн дагуу суутгасан 1,843.7 мянган төгрөгийн суутгалыг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.5, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого (татвар ба шилжүүлэг), НББОУС 18 Орлого , MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн,*

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,



мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", ангилал батламж мэдэгдлийг хангаагүй

### **Залруулаагүй алдаа:**

Байхгүй

Аудитаар нийт 9,742.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 1,016.4 мянган төгрөгийн төлбөрийн акт, 8,726.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн байна.

#### **5.1 Төлбөрийн акт**

5.1.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдсэн 2 албан хаагчид 1,016.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д "Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна", 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.5-д "Үнэлгээний баг албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн, үнэлгээний 85-100 оноог "Маш сайн", 70-85 хүртэлх оноог "Хэвийн", 70 хүртэлх оноог "Хангалтгүй" үнэлгээний ангилалд хамруулан эрэмбэлнэ", 6.6-д "Үнэлгээний баг нь үнэлгээний ангиллаас хамааран холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт болон байгууллагын дотоод журмыг баримтлан доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаарх саналыг төсвийн шууд захирагчид гаргана", 6.6.3-т "Хангалтгүй" үнэлгээний ангилалд хамрагдсан төрийн албан хаагчийн хувьд: а). сургалтад хамруулах (албан хаагчийн өөрийн зардлаар), б). Төрийн албаны тухай хуульд заасан сануулах арга хэмжээ авах, в). албан тушаалын цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, г). албан тушаал бууруулах (2 удаа дараалан "Хангалтгүй" үнэлгээний ангилалд хамрагдсан), д). төрийн албанаас халах (сүүлийн 2 жилийн үнэлгээгээр 3 удаа "Хангалтгүй" үнэлгээний ангилалд хамрагдсан) дахь заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

#### **5.2 Албан шаардлага**

5.2.1 Орон тоо, төсөв батлагдаагүй 2 орон тоонд / гамшиг, ХАБЭА/ 2 албан хаагчид ажил хавсарсны нэмэгдэл 8,726.5 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх", 4.1.9-д "хариуцлагатай байх", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.2-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох", 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон тоо, төсөв батлагдаагүй 2 орон тоонд ажил хавсарсны нэмэгдэл олгосон зөрчлийг таслан зогсоож, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Цалин, хөлстэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Он удаан жил болсон нийт 31,859.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллаагүй, хуульд заасан үүргээ биелүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын удирдлага авлагын үлдэгдлийг барагдуулах чиглэлээр ажлын хэсэг томилох, ажлын хэсэг төлөвлөгөө гаргах, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийг төлөвлөгөөг хуулийн хугацаанд тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Дүн		Дүн		Дүн		Залруулсан		Залруулаагүй		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн шинж чанаргүй 2,690.0 мянган төгрөгийн 3 хөрөнгийг машин тоног төхөөрөмж дансанд бүртгэж, 10 жилийн ашиглалтын хугацаатай орлогод авсан	1	2,690.0			1	2,690.0	1	2,690.0				
2 дугаар сард ажлын цагийн тооцоо гаргаагүй	1	0.0	1	0.0			1	0.0				
Тайлант хугацаанд өмнөх онд үүссэн 1,680.0 мянган төгрөгийн албан томилолтын өглөгийг барагдуулаагүй	1	1,680.0			1	1,680.0	1	1,680.0				
300.7 мянган төгрөгийн шатахууны зардлыг арвилан хэмнэлтгүй зарцуулсан /Жолоочийн тооцооны хуудсанд сумаас аймаг руу ирж, очих км-ийг ялгаатай, харилцан адилгүй тооцоолсон/	1	300.7			1	300.7	1	300.7				
Жилийн эцсээр ахмадын сангийн дансанд төвлөрүүлсэн 15,434.6 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч алдаатай бүртгэсэн	1	15,434.6			1	15,434.6	1	15,434.6				
Сумын Орон нутгийн хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцөлийг дэмжих, байр засварлах" засварын ажлыг үндсэн хөрөнгийн барилга байгууламж дансанд хөрөнгийн өртгийг нэмэгдүүлж хөрөнгийн сайжруулалт хийж бүртгэсэн	1	276,001.3			1	276,001.3	1	276,001.3				

Үр дүнгийн тайланд сахилтын шийтгэл ногдуулах шийдвэрийн дагуу суутгасан суутгалыг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй	1		1,843.7		1		1,843.7		1		1,843.7	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	7	297,950.3	2	1,843.7	5	296,106.6	7	297,950.3				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орон тоо, төсөв батлагдаагүй орон тоонд /гамшиг, ХАБЗА/ 2 албан хаагчид ажил хавсарсны нэмэгдэл 8,726.5 мянган төгрөгийг олгосон	1	8,726.5			1	8,726.5						
Гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдсэн 2 албан хаагчид 1,016.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон	1	1,016.4	1	1,016.4								
Он удаан жил болсон нийт 31,859.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллаагүй, хуульд заасан үүргээ биелүүлээгүй	1	0.0					1	0.0				
Дүн	3	9,742.9	1	1,016.4	1	8,726.5	1	0.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/									
	Нийт зөрчил		Төлбөрийн акт				Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5-н сая төгрөгөөс дээш худалдан авалт цэст 277,729.2 мянган төгрөгийн 14 худалдан авалтыг мэдээлсэн боловч бараа ажил үйлчилгээний нэр, ажил үйлчилгээний утга тодорхойгүй мэдээлсэн, нийт 53,547.1 мянган төгрөгийн 14 шийдвэр хугацаа хоцорч мэдээлсэн	1	0.0							1	0.0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0.0</b>							<b>1</b>	<b>0.0</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
<b>Дүн</b>										
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0.0</b>							<b>1</b>	<b>0.0</b>

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Шивээговь сумын Засаг даргын тамгын газар  
Байгууллагын РД: 9018441

Аудитын код: ГСА-2025/056/НА-СТА-ТШЗ  
Аудитын нэр: Санхүүгийн тайлангийн аудит  
Тайлант хугацаа: 2024.01.01-2024.12.31

№	АГАДҮТ	АГАДҮТ-ийн дэд анги	Алдаа, зөрчлийн төсө утга	Мөнгөн дүн /төгрөгөөр/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгалдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгалдагч байгууллагын холбогдох хүний Албан тушаал	Овог нэр
<b>1. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдааны бүртгэл</b>										
1	Тодруулга-Үндсэн хөрөнгө	Үндсэн хөрөнгө	Үндсэн хөрөнгийн шийж чанаргүй 3 хөрөнгийг машин тоног-товхөөрөж дансанд бүртгэж, 10 жилийн ашиглалтын хугацаатай орлогод авсан	2,690,000.0	Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн	Зөвшөөрсөн	Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн	Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн	Дарга, нягтлан бодогч	Д.Отгонжаргал, Л.Туяа
2	Урсгал зардал	Цалин	2 дугаар сард өмнөх цагийн тооцоо гаргаагүй	-	Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн	Зөвшөөрсөн	Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн	Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн	Дарга, нягтлан бодогч	Д.Отгонжаргал, Л.Туяа
3	Нийт зардал	Зардал	Тайлант хугацаанд өмнөх онд үүссэн албан томиголын өгслийг барагдуулаагүй	1,680,000.0	Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн	Зөвшөөрсөн	Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн	Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн	Дарга, нягтлан бодогч	Д.Отгонжаргал, Л.Туяа
4	Нийт зардал	Зардал	Тээвэр шатахууны зардлыг ариулан хэмнэлттэй зарцуулсан /Жолоочийн тооцооны хуудсанд сумас аймаг руу ирж, очих гай-ийг ялгаатай, харилцан адилгүй тооцосон./	300,697.0	Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн	Зөвшөөрсөн	Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн	Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн	Дарга, нягтлан бодогч	Д.Отгонжаргал, Л.Туяа
5	Нийт орлого	Орлого	Жилийн эцсээр ахмадын сангийн дансанд төвлөрүүлсэн, 15,434.6 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнтэй тайланд орлогоор хүлээн зөвшөөрч алдаатай бүртгэсэн	15,434,656.0	Залруулах	Зөвшөөрсөн	Залруулах	Залруулах	Дарга, нягтлан бодогч	Д.Отгонжаргал, Л.Туяа
6	Тодруулга-Үндсэн хөрөнгө	Үндсэн хөрөнгө	Сумын Орон нутгийн хөгжил хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Төрийн албан хаагчийн амьдрах орчин нөхцлийг дэмжих байр засварлах" засварын ажлыг үндсэн хөрөнгийн барилга байгууламж дансанд хөрөнгийн өртгийг нэмэгдүүлж хөрөнгийн сайжруулалт хийж бүртгэсэн	276,001,267.0	Залруулах	Зөвшөөрсөн	Залруулах	Залруулах	Дарга, нягтлан бодогч	Д.Отгонжаргал, Л.Туяа
7	Нийт орлого	Орлого	Үр дүнтэй тайланд сахилтын шимтлэл ногдуулах шийдвэрийн дагуу суутгасан суутгалыг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй	1,843,710.0	Залруулах	Зөвшөөрсөн	Залруулах	Залруулах	Дарга, нягтлан бодогч	Д.Отгонжаргал, Л.Туяа
<b>Алдааны дүн</b>				<b>297,950,330.0</b>						
<b>2. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн бүртгэл</b>										
1	Урсгал зардал	Цалин	Орон тоо, төсө багтаалдаагүй байвал, 2 албан хаагчид ажил хавсаргы нэмэгдэл 8,726.5 мянган төгрөгийг олгосон	8,726,547.0	Албан шаардлага өгөх	Зөвшөөрсөн	Албан шаардлага өгөх	Албан шаардлага өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Отгонжаргал, Л.Туяа
2	Урсгал зардал	Цалин	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдсэн 2 албан хаагчид хууль тогтоомж зөрчиж, 1,016.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон	1,016,400.0	Төлбөрийн акт тогтоох	Зөвшөөрсөн	Төлбөрийн акт тогтоох	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Д.Отгонжаргал, Л.Туяа
3	Тодруулга-Авлага	Авлага	Он удаан жил болсон нийт 31,859.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллаагүй, хуульд заасан Үүргээ биелүүлээгүй	-	Зөвлөмж өгөх	Зөвшөөрсөн	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Отгонжаргал, Л.Туяа
<b>Зөрчлийн дүн</b>				<b>9,742,947.0</b>						
<b>3. Нийцлийн аудитын асуудлын бүртгэл</b>										
1	Шилэн данс	Шилэн данс	Шилэн дансны нэгдсэн цэвэр хуудсанд, 5-н сая төгрөгөөс дээш хуудсанд авалт /цэвэр/ 277,729.2 мянган төгрөгийн 14-хуудсанд авалтыг мэдээлсэн боловч өөрөө ажил үйлчилгээний нэр, ажил үйлчилгээний утга тодорхойгүй мэдээлсэн, нийт 53,547.1 мянган төгрөгийн 14 шийдвэр хугацаа хоцорч мэдээлсэн	-	Зөвлөмж өгөх	Зөвшөөрсөн	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Д.Отгонжаргал, Л.Туяа
3	Нийцлийн аудитын асуудлын дүн		Нийт алдаа, зөрчлийн дүн	307,693,277.00						

Бэлтгэсэн: Ахлах аудитор /Б.Ариутуев / Огноо: 2025.02.13  
Ханасан: Аудитын менежер /Г.Нарансар / Огноо: 2025.02.13  
Ханасан: Дарга, Тэргүүлэх аудитор /Б.Сарантуяа / Огноо: 2025.02.13



4217144454  
УСА0055 9019049



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар

16/А0861082

ГСА-2025/056/НА-СГА-ТЦЗ.

Чойр

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн "Шивээговь сумын Засаг даргын тамгын газар"-ын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдсэн 2 албан хаагчид 1,016.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д "Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна", 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.5-д "Үнэлгээний баг албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн, үнэлгээний 85-100 оноог "Маш сайн", 70-85 хүртэлх оноог "Хэвийн", 70 хүртэлх оноог "Хангалтгүй" үнэлгээний ангилалд хамруулан эрэмбэлнэ", 6.6-д "Үнэлгээний баг нь үнэлгээний ангиллаас хамааран холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт болон байгууллагын дотоод журмыг баримтлан доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаарх саналыг төсвийн шууд захирагчид гаргана", 6.6.3-т "Хангалтгүй" үнэлгээний ангилалд хамрагдсан төрийн албан хаагчийн хувьд: а).сургалтад хамруулах (албан хаагчийн өөрийн зардлаар), б).Төрийн албаны тухай хуульд заасан сануулах арга хэмжээ авах, в).албан тушаалын цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, г).албан тушаал бууруулах (2 удаа дараалан "Хангалтгүй" үнэлгээний ангилалд хамрагдсан), д)төрийн албанаас халах (сүүлийн 2 жилийн үнэлгээгээр 3 удаа "Хангалтгүй" үнэлгээний ангилалд хамрагдсан) гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно," Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага

42250900

өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", "4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль тогтоомж зөрчиж олгосон урамшууллын 1,016,400.0 /Нэг сая арван зургаан мянга дөрвөн зуун/ төгрөгийг удирдлага, санхүүгийн ажилтан нар хариуцан барагдуулж, Говьсүмбэр аймгийн Төрийн сан дахь **орон нутгийн орлогын "Төсөвт байгууллагын өөрийн орлого" 100220000954** тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 25-ны дотор өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын дарга Д.Отгонжаргал, нягтлан бодогч Л.Туяа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Г.НАРАНБАЯР

Б.АНХТУЯА

<sup>1</sup> Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, Нутгийн удирдлагын ордон, Утас:70543179



2025 оны 16/АД861082 дугаартай төлбөрийн актын хавсралт



**“Шивээговь сумын Засаг даргын тамгын газар”-ын төлбөрийн актын жагсаалт**

4217144454  
УСА0055 9019049

Д/Д	Албан тушаалтны нэр	Төлбөрийн актын дүн
1	П.Ганжаргал	508,200.0
2	Б.Алтансүх	508,200.0
<b>Нийт дүн</b>		<b>1,016,400.0</b>



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар

17/А086/082  
ГСА-2025/056/НА-СТА-ТМЗ

Чойр

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хүрээнд Говьсүмбэр аймгийн “Шивээговь сумын Засаг даргын тамгын газар”-ын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Орон тоо, төсөв батлагдаагүй 2 орон тоонд /гамшиг, ХАБЭА/ 2 албан хаагчид ажил хавсарсны нэмэгдэл цалин нийт 8,726.5 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “сахилга баттай байх”, 4.1.9-д “хариуцлагатай байх”, 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.2-т “чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”, 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.4-т “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн”, 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон тоо, төсөв батлагдаагүй байхад ажил хавсарсны нэмэгдэл олгосон зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг бүрэн арилгаж, биелэлтийг 2025 оны 05

422504060

дугаар сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын дарга Д.Отгонжаргал, нягтлан бодогч Л.Туяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Г.НАРАНБАЯР

Б.АНХТУЯА

<sup>1</sup> Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын  
2025 оны 14/А.006/106 дугаартай албан шаардлагын хавсралт

“Шивээговь сумын Засаг даргын тамгын газар”-ын албан шаардлагын жагсаалт

4217144454  
УСА0055 9019049

Д/Д	Хавсарсан албан тушаалын нэр	Мөнгөн дүн
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	4,341,200.0
2	Гамшиг	4,385,347.0
<b>Нийт дүн</b>		<b>8,726,547.0</b>

